

ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Чөлөөт сонголд оролцсон хүнд олгов

Ерөнхий маягт

Доорхи мэдээлэл таны ойлгодог хэл дээр бичигдэн өгөгдсөн байх шаардлагатай.

Та зөрчил гэмт хэрэг гаргасан буюу гаргахыг завдсан шалтгаанаар сэжиглэгдэн таны эсрэг үүнийг батлах нэг буюу хэдэн зохих шалтгаан гарсан тулд таныг түр хорих баривчлах болсон гэдгийг танд мэдэгдсэн болно.

Таныг үйлдсэнд сэжиглэж буй гэмт хэрэг зөрчилийн байдал, огноо ба байршилийг мэдэж авах эрхтэй.

Та өөрийн сонгол шүүх хурал явагдах байр газрыг өөрийн дуртай цагт орхиж явах эрхтэй.

ТА ДООРХИ ЭРХ ЭДЛЭХИЙГ ТАНД МЭДЭЭЛЖ БАЙНА :

Өргөдөл гаргах, чимээгүй үг хэлэхгүй байх эсвэл асуултанд хариулах.

Нэг удаа өөрийн биеийн байцаалтыг үгүйсгэсэн тохиолдолд та хурал дээрээ доорхи эрхийг эдлэнэ :

- өргөдөл гаргах,
- асуулсан асуултууданд хариулах,
- эсвэл үг хэлэхгүй байх.

Өмгөөлөгчийн тусламж

Хэрэв таны гаргасан зөрчилийг гэмт хэрэг буюу эсвэл шоронд хорихоор ялтай зөрчил буюу гэмт хэрэг гэж үзсэн бол та өөрийн шүүх хурлын явцад туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн тусламжийг авч болно.

Өмгөөлөгчийн сонголт

Та өөрийн сонгосон өмгөөлөгчийн тусламжийг авах бүрэн эрхтэй. Хэрэв та өөрөө өмгөөлөгчөө заан сонгох чадаргүй эсвэл боломжгүй бол та өмгөөлөгчдийн хорооны ажилтнаар заагдсан өмгөөлөгчийг аван туслуулах эрхтэй ба боломжтой.

Үүний хөлс төлбөр нь таны талаас гарах ба хэрэв та таньд олгогдсон хавсралтын баримтуудад заагдсан шүүхийн тусламж авах болзол нөхцөлүүдийг хангаж байгаа тохиолдолд та төлбөрийг өөрөө төлөхгүй.

Өмгөөлөгчийн тусламж

Өмгөөлөгч нь :

- ярилцлагын нууцыг чанд хадгалсан байдалд таньтай ярилцлага явуулах;
- таны шүүх хурал буюу сонголд оролцох эрхтэй.

Мөн тө өөрийн өмгөөлөгчийг байхгүй тохиолдолд ч хуралд оролцохыг зөвшөөрөх ёстой.

Хэлмэрчийн туслалцаа авах

Хэрэв та франц хэлээр ярьдаггүй буюу ойлгодоггүй тохиолдолд та өөрийн өмгөөлөгчтэй ярилцах, шүүх хурал сонголд оролцох зэрэгт үнэ төлбөргүй байдлаар хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Өөрийн хэргийн хавсарсан материалуудтай танилцах

Таны хүсэлтээр буюу эсвэл таны өмгөөлөгчийн хүсэлтээр та өөрийн хэргийн материалуудтай танилцахыг шаардах эрхтэй.

Шүүхийн зөвлөлгөө авах

Та үнэ төлбөргүй хэлбэрээр зохих байгууламжаас шүүхийн зөвлөлгөө авах эрхтэй бөгөөд уг зөвлөлгөө авах хуулийн байгууламжтай холбогдох хаяг танд хавсралтанд буй баримтанд заагдсан байна.